

1. Орон нутгийн Шүүхийн шинжилгээний албадыг шаардлагатай орон тоо, материаллаг баазаар хангаж, үйл ажиллагааг нь тогтворжуулан бэхжүүлэх.

3. Шинжээч, мэргэжилтэний хүний нөөцийн цогц бодлого боловсруулах.

2. Албуудыг үйл ажиллагаагаа явуулахад стандартын шаардлага хангасан байртай болгох тал дээр анхаарах төрөөс нэгдсэн бодлогоор дэмжих.

3. Байгууллагын үйл ажиллагааг цогц болгохын тулд эрх зүйн зохицуулалтуудыг сайжруулах арга хэмжээ авах

4. Шуурхай удирдлагын автомашинаар нэгдсэн журмаар хангуулах, түлш шатахууны төсвийг суулгах, хэргийн газрын үзлэгийн техник хэрэгсэл, төхөөрөмжийг шинэчлэх.

6. Манай байгууллага хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний “хөгжлийн стратеги хөтөлбөр 2008-2021”-г алба хаагчдыг ажлын байранд 3 жил тутамд мэргэшүүлэн сургана ¹ гэсэн заалт байгаа энэ заалтын хэрэгжилт хараахан сайн хэрэгжихгүй байна. Иймд цахим сургалт орох орчинг бүрдүүлвэл өртөг хямд хугацаа богино байх боломжтой юм.

*Ж.Тамир -Хууль сахиулахын удирдлагын академийн
821 дүгээр дамжааны суралцагч, цагдаагийн ахлах дэслэгч*

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ АЖИЛЛАГАА ДАХЬ ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГЫН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

Хураангуй. Энэхүү илтгэлээр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа дахь шүүхийн шинжилгээний байгууллагын удирдлагын эрх зүйн байдлын өнөөгийн байдал, эрх үүргээ хэрэгжүүлэхэд үүсч буй зарим асуудал, түүнээс гарах арга замыг эрэлхийлэхийг зорилоо.

Түлхүүр үг. Шүүхийн шинжилгээний байгууллагын удирдлага, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа, шинжээчийн дүгнэлт, шинжилгээний магадлагаа, мэргэжилтний дүгнэлт, тусгай мэдлэг, тусгай чадвар

Манай Улсын хувьд 2009 онд Шүүхийн шинжилгээний байгууллага нь бие даасан хуультай болсон бөгөөд энэхүү өөрчлөлтөөр эрхзүйн байдлын хувьд олон талын дэвшил гарсан гэж судлаачид үздэг боловч шүүхийн шинжилгээний байгууллагын удирдлагын эрүүгийн байцаан шийтгэх

¹ хууль зүй дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “хөгжлийн стратеги хөтөлбөр” 2008-2021 81 дэх тал

ажиллагаа дахь эрх зүйн зохицуулалт, иж бүрэн¹ болон бүрэлдэхүүнтэй шинжилгээний шинжээчдийн бүрэлдэхүүнийг томилох, зохион байгуулах үйл ажиллагааны зохицуулалтыг орхигдуулсан гэж судлаач бид үзэж байна.

Тиймээс Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь шүүхийн шинжилгээний байгууллагын удирдлагын эрх зүйн байдлын тулгамдсан асуудлуудыг цогц байдлаар авч үзэн шүүхийн шинжилгээний байгууллагын удирдлагын ажил байдлын чиг үүргийн боловсронгуй болгох, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд тусдаа чиг үүрэг бүхий статустай оролцогчын хэмжээнд оролцох, үйл ажиллагааг эрх зүйн зохицуулалтанд оруулах арга замыг шинжлэх ухааны судалгааны үндсэн дээр дэвшүүлэн гаргаж үнэлэлт, дүгнэлт өгөх зайлшгүй хэрэгцээ шаардлага байна.

Түүхэн уламжлалын хувьд 1963 оноос 2002 оныг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байсан ЭБШХ-ийн 185 дугаар зүйлд^{1 2}:

Зохих шинжилгээний байгууллагын шинжээчээр шинжилгээ хийлгэхээр даалгахад мөрдөн байцаагч буюу хэрэг бүртгэгч өөрийн тогтоол ба шинжилгээ хийхэд зайлшгүй шаардлагдах материалыг уг байгууллагад явуулна.

Шинжилгээний байгууллагын удирдлага тогтоолыг хүлээн авмагц өөрийн байгууллагын нэг буюу хэсэг хүмүүст шинжилгээ хийлгэхээр даалгавар өгнө.

Шинжилгээний байгууллагын удирдлага шинжилгээ хийхээр даалгавар авсан хүмүүст шинжээчийн эрх, үүргийг тайлбарлан өгч дүгнэлт өгөхөөс татгалзах буюу зайлсхийх, эсхүл санаатайгаар худал дүгнэлт өгвөл хариуцлага хүлээлгэхийг урьдчилан сануулж, тэр тухай тэднээс гарын үсэг авч шинжээчийн дүгнэлтийн хамтаар мөрдөн байцаагч буюу хэрэг бүртгэгчид явуулна гэж тус тус хуульчилсан байсан нь эрх зүй, зохион байгуулалтын хүрээнд шинжилгээний байгууллагын удирдлагын эрх зүйн байдал, чиг үүргийг процессын хэмжээнд тодорхой харуулсан байсан байна.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа дахь шинжээч, мэргэжилтний эрх зүйн байдал болон шинжилгээний байгууллагын удирдлага эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогч болох хууль зүйн болон шинжлэх ухааны үндэслэлтэй эсэх талаар хууль зүйн ухааны доктор Бө.Бат-Эрдэнэ

¹ Англиар complete examination, оросоор комплексная экспертиза гэсэн хоршоо үгээр илэрхийлж байна. Янз бүрийн төрлийн өөр мэргэжил бүхий шинжээчлийн хамтран хийсэн шинжилгээ.

² 1963 оны Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль

“Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь шинжээч, мэргэжилтний эрх зүйн байдал” сэдэвт хууль зүйн ухааны докторын зэрэг хамгаалсан эрдэм шинжилгээний бүтээлдээ судалж 2002 онд батлагдсан Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулиар шүүхийн шинжилгээний байгууллагын удирдлагын эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь эрх зүйн байдлыг хуульчилж өгөөгүй нь практикт олон эрсдлүүдийг дагуулсан гэж үзээд цаашид шүүхийн шинжилгээний байгууллагын удирдлагын эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь эрх зүйн байдлыг хуульчлах, боловсронгуй болгох нь зүйтэй гэж үзсэн байна.

Судалгааны явцад Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа дахь Шүүхийн шинжилгээний байгууллагын удирдлагын эрх зүйн байдал болон шинжилгээ хийхтэй холбогдсон харилцааг зохион байгуулах асуудлын талаар Т.В.Аверьянова, Р.С.Белкин Н.П.Майлис Е.Р.Российская нарын эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлд саналын түвшинд тусгагдсан байх ба эдгээр судлаачид шүүхийн шинжилгээний онол, практикийн үндсэн асуудал, тусгай мэдлэгийг шүүн таслах ажиллагаанд ашиглах асуудлын суурь судалгаанд үлэмж хувь нэмэр оруулсан байна.

Сэдвийн хүрээнд Украин Улсын эрдэмтэн И.П.Кононенко 1975 онд хэвлүүлсэн “Криминалистик ба шүүхийн шинжилгээ” бүтээлдээ эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа дахь шүүхийн шинжилгээний байгууллагын даргын эрх зүйн байдлыг боловсронгуй болгох, нэмэгдүүлэх, эрх зүйн зохицуулалтуудыг эрүүгийн байцаан шийтгэх хуульд хуульчлах шаардлагатай талаар харьцуулсан судлал хийж үнэлэлт дүгнэлт өгч санал’ дэвшүүлсэн байна.

Мөн Оросын холбооны Улсын эрдэмтэн В.М.Быков 2008 онд хэвлүүлсэн “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа” бүтээлдээ “Шүүхийн шинжилгээний байгууллагын удирдлага болон шинжээч, мэргэжилтний эрх зүйн байдал”^{1 2}, А.Н.Петрухины 2006 онд хэвлүүлсэн “Криминалистикийн шинжээч” бүтээлдээ “Шүүхийн шинжилгээний байгууллагын удирдлагын эрхийн хэм хэмжээ”³-ий талаар бичиж эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бүх үе шатанд түүний хэлбэр, баталгаа, бүтэц, бүтэц, зохион байгуулалт, зорилтыг тодорхойлохын тулд шүүхийн шинжилгээний

¹ Кононенко, И.П. Криминалистика и судебная экспертиза. 1975. Киев. С. 134-144

² Быков, В.М. Правовое положение эксперта и руководителя экспертного учреждения Текст. / В. М. Быков // Уголовный процесс. 2008. -№2.-С. 51 -54

³ Петрухина, А.Н. Правовой статус руководителя судебно-экспертного учреждения Текст. / А.Н. Петрухина // Эксперт-криминалист. -2006.-№1.-С. 11-12

байгууллагын удирдлагын эрх зүйн дэмжлэг туслалцаа чухал тул түүний эрх зүйн байдлыг боловсронгуй болгох шаардлагатай гэж үзсэн байна.

ОХУ-ын ЭБШХ-ийн 5 дугаар зүйлд¹: “Шинжилгээ хийх эрх бүхий байгууллага гэж шинжлэн магадлах төрийн байгууллага, эсвэл энэ хуульд заасан журмын дагуу шинжилгээ хийхийг даалгасан бусад байгууллагыг хэлнэ” гэсэн тодорхойлолт байна. Энд шүүхийн шинжилгээ биш, шинжлэн магадлах гэж шүүн таслах ажиллагааг бүхэлд нь хэлсэн байгааг зориуд дурьдвал зохино.

Хэрэв шүүхийн гэж тэмдэг нэрээр ойлгох юм бол тэр байгууллага өөрийн харъяалагддаг шүүхдээ л ганцхан үйлчлэх логик агуулга харагдаж байгаа тул цагдаагийн, прокурорын, тагнуулын гэхчлэн шинжилгээний байгууллага байгуулах шаардлага харагдаж байна.

Ер нь “шинжилгээний байгууллагын удирдлага” гэсэн ойлголтыг зөвхөн шинжилгээний байгууллагын тодорхой нэг дарга, хувь хүний тухай төсөөллөөр бус байцаан шийтгэх ажиллагааны субъект, институци гэсэн утгаар авч үзэх нь онолын үүднээс зүйтэй гэж бид үзэж байна^{1 2}.

Энэхүү субьектийн эрх, үүргийг хууль тогтоомжоор тодорхой болгосноор шинжилгээг шинжилгээний байгууллагаар хийлгэх онцлог тодорхой болж, шинжилгээний цогц байдал бий болох нь тодорхой.

Шинжилгээний цогц байдлыг бий болгох гэдгийг аливаа хэргийн болсон байдлыг тогтоох зорилгоор тухайн хэрэгт холбогдолтой баримтуудыг тал бүрээс нь судлан шинжлэх, улмаар хоорондын логик холбоог бүхэлд нь нэгтгэн дүгнэх боломжийг нээн гаргах, өөрөөр хэлбэл тусгай мэдлэг шаардсан асуудлыг аль болох цогцоор нь шийдэхийг хэлнэ³.

Дээрх асуудлыг шийдвэрлэхэд шинжилгээний байгууллагын бүтэц зохион байгуулалт, сургалт, хүний нөөцийн бодлого, техник тоног төхөөрөмжийн хангалт, төсөв санхүүгийн асуудал зайлшгүй холбогдох боловч юуны түрүүнд эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох, түүнийг хэрэгжүүлэх, оролцох субьектүүдийг оновчтой зохион байгуулах нь нэн тэргүүний зорилт гэж үзэж байна. Дээр дурдсан асуудлыг шийдвэрлэх эхний алхам бол өнөөгийн мөрдөж буй хуулийн хүрээнд шинжилгээний байгууллагын удирдлагын эрх зүйн байдлын хэм хэмжээнүүдийн

¹ УПК РФ. Ст.5.1.

² Б.Бат-Эрдэнэ. Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь шинжээч, мэргэжилтний оролцоо. Дисс. М., 2009.

³ Т.Очирбат., “ЭБША дахь мэргэжилтний оролцоо нь хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагааны тулгамдсан асуудлын нэг болох нь”, УБ.,2014., Эрдэм шинжилгээний илтгэл

зохицуулалтыг хийх, “Шинжилгээг шинжилгээний байгууллагад хийх” журам боловсруулах шаардлагатай байна.

Манай улстай төстэй эрх зүйн тогтолцоотой бусад улс орны туршлагаас үзэхэд Эрүүгийн процессийн ажиллагаанд оролцогч шинжилгээний байгууллагын даргын эрх зүйн байдлыг процессийн хууль тогтоомжоор тодорхой зааж өгсөн байна. Тухайлбал, ОХУ болон түүнээс салан тусгааралсан Гүрж, Казакстан, Тажигстан, Узбекистан зэрэг улсууд Эрүүгийн процессийн процессийн хууль тогтоомждоо шинжилгээний байгууллагын даргын эрх, үүргийг тодорхойлохдоо:

- шинжилгээний байгууллагын удирдлага шинжилгээг хүлээн авч тогтоолд тавьсан асуултын хүрээнд шаардлагатай тусгай мэдлэг эзэмшсэн тодорхой шинжээч, эсвэл тухайн байгууллагын шинжээчдийн бүрэлдэхүүнд даалгах;

- шинжээч, эсвэл шинжээчдийн бүрэлдэхүүнд эрх үүргийг нь тайлбарлах, зориуд худал дүгнэлт гаргавал хүлээлгэх хариуцлагыг урьдчилан сануулах;

- шинжилгээ хийх хугацаа, шинжилгээг бүрэн дүүрэн, чанартай хийж байгаа, шинжээчийн хараат бус байх зарчмыг алдагдуулахгүй байхад хяналт тавих;

- шинжилгээг хийж дууссаны дараа шинжээчийн дүгнэлт, объект, материалыг шинжилгээ томилсон байгууллага, этгээдэд хүргүүлэх; зэрэг үүрэгтэй бөгөөд

- шинжилгээ хийлгэхийг даалгасан байгууллага, этгээдэд шинжилгээ хийх комиссын бүрэлдэхүүнд шинжилгээ хийхэд шаардлагатай тусгай мэдлэг бүхий, тухайн байгууллагад ажилладаггүй шинжээчийг оролцуулж өгөх хүсэлт гаргах;

- шинжилгээ хийлгэхийг даалгасан тогтоол, захирамжид заасан өөр байгууллагыг оролцуулан шүүх шинжилгээ хийх ажиллагааг зохион байгуулах;

шинжилгээ хийхэд тусгай мэдлэг ашиглах шаардлагатай тохиолдолд шүүхийн шинжилгээний байгууллагын дарга шинжилгээ хийлгэх гэрээ байгуулах эрхтэй болохыг заасан байна.

Бид судалгааны үр дүнг нэгтгэн, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх дараах дүгнэлт, саналыг гаргаж байгаа бөгөөд үүнийг хэрэгжүүлснээр шүүхийн шинжилгээний үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгтгэн зангидаж, шинжлэх ухаан, техник технологи, хууль зүй, хүний хүчин зүйлийн шалгуурт нийцсэн, нотлох баримтын хэмжээнд

үнэлэгдэхүйц дүгнэлт, магадлагааг түргэн шуурхай, хүндрэл чирэгдэлгүй гаргах нөхцөл бүрдэх нэг алхам болно гэж үзэж байна.

1. Манай улсын шүүхийн шинжилгээний байгууллага идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг байх эрх зүйн боломжийг бүрдүүлэх шаардлагатай. Учир нь улсын хэмжээнд нэгдмэл шүүхийн шинжилгээний байгууллагатай, шүүхийн шинжилгээ хийхээс гадна хэргийн газрын үзлэгт оролцдог мэргэжилтнүүд бүгд энэ байгууллагад харьяалагддаг онцлогтой.

2. Эрүүгийн байцаан шийтгэх хууль, шүүхийн шинжилгээний тухай хууль болон бусад эрх зүйн хэм хэмжээний актуудаар тусгай мэдлэг ашиглах бүхий л хэлбэрийг шүүхийн шинжилгээний байгууллагад нэгтгэсэн боловч шүүхийн шинжилгээний байгууллагын зарим үйл ажиллагааны эрх зүйн орчин тодорхой бус байгаагаас практикт олон эргэлзээтэй асуудлуудыг дагуулж байна.

3. Шинжилгээний байгууллагад шинжилгээ хийх онцлогийг тусгасан заалтыг Шүүхийн шинжилгээний тухай хуульд нэмж оруулах, эхний ээлжинд энэ онцлогийг тусгасан журмыг боловсруулж батлуулан мөрдөх нь зүйтэй.

Энэ журамд шинжилгээний байгууллагын удирдлага /институци/-ын эрх, үүргийг тодорхойлох, улмаар шинжилгээ хийхээр шийдвэрлэх, бусад тусгай мэдлэг ашиглахаар бол гэрээт байгууллага, лаборатори, мэргэжилтэнд хандаж магадлагаа гаргуулан шинжилгээнд ашиглах, гаднын байгууллагаас тусгай мэдлэгтэй хүнийг шинжээчдийн бүрэлдэхүүнд оролцуулахаар бол шүүхийн шинжилгээний байгууллага бие даан шийдвэрлэх нь зүйтэй байна.

4. Шинжлэх ухааны хөгжлийн явцад шүүхийн шинжилгээний онолын үндэс, практик ач холбогдлыг нээн илрүүлэх, боловсронгуй болгох зайлшгүй хэрэгцээ, шаардлага бий болсоны улмаас эрдэмтэн судлаачид шүүхийн шинжилгээний байгууллагын удирдлагын эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа дахь эрх зүйн байдлыг өргөжүүлэх, нарийвчлан тодорхой болгох, боловсронгуй болгох зайлшгүй хэрэгцээ шаардлагатай.